

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
Т А Й Л А Н

/2016 оны жилийн эцсийн байдлаар/

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын 2015 оны 52 дугаар тогтоолыг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуйн Сайдын 2016 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн А/30 дугаар тушаалаар “Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г батлуулан хэрэгжүүлж байна. Уг төлөвлөгөөний дагуу макро эдийн засгийн бодлого, эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого, бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлогын хүрээнд 6 зорилтот 35 арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулжээ.

Хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго нь төлөвлөгөөний гүйцэтгэлийг хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудад мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэж байна.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Тусгагдсан арга хэмжээний 2016 оны жилийн эцсийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор батлагдсан “Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам”-ыг удирдлага болгон, хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтооход “Үр дүнг үнэлэх аргачлал”-ыг баримталж ажилласан болно. Уг тайлангийн 3 дугаар хавсралтыг Засгийн газрын 322 дугаар тогтоолоор баталсан журмын 8 дугаар хавсралтын дагуу бэлтгэж гаргав.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг яамны Төрийн захиргааны удирдлагын газраас нэгтгэн ирүүлсэн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тайланг нягтлан үзэх, зарим арга хэмжээний хэрэгжилтийг хариуцсан албан тушаалтнуудтай уулзаж тодруулах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн тайланг бэлтгэсэн болно. Төлөвлөсөн арга хэмжээ бүрээс хэрэгжүүлэх хугацааны төгсгөлд гарах дүнг урьдчилсан байдлаар тогтоож, үнэлгээ хийх үед гарсан бодит үр дүнгийн түвшинтэй харьцуулж хувиар илэрхийлэн үнэлгээг тодорхойлов.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах арга хэмжээний ерөнхий гүйцэтгэл 2016 оны жилийн эцсийн байдлаар 80.3 хувьтай үнэлэгдэж байна. Төлөвлөгдсөн арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 16 арга хэмжээ байгаа бол 8 нь 90 хувьтай, 3 нь 70 хувьтай, 5 нь 50 хувьтай, 3 нь 10 хувийн хэрэгжилттэй байна. Тасарсан арга хэмжээ байхгүй болно.

Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг салбар бүрээр авч үзвэл Бодлого, төлөвлөлтийн газар 2 арга хэмжээ, 30 хувийн, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 18 арга хэмжээг 88.8 хувийн, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 7 арга хэмжээг 84.3 хувийн, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 5 арга хэмжээг 90.0 хувийн, Жижиг дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 3 арга хэмжээг 50.0 хувийн, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 1 арга хэмжээг 50.0 хувийн гүйцэтгэлтэйгээр тус тус хэрэгжүүлсэн байна.

Хүрэх түвшингээ хэт өндөр тавьсан буюу төлөвлөлтийн алдаанаас шалтгаалан “12.6.1. “Монгол мал хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийг хөгжүүлэх хүрээнд хоршоодыг дэмжиж бүх сумдад мал аж ахуйн гаралтай бараа, түүхий эд бэлтгэх үндэсний сүлжээ бий болгох” арга хэмжээ нь нэг жилийн хугацаанд бүх сумдад бараа, түүхий эд бэлтгэх үндэсний сүлжээ бий болгохоор заасан арга хэмжээний биелэлт хангалтгүй байна. Энэхүү арга хэмжээнд хөрөнгө төлөвлөөгүйгээс гадна нэг жилийн хугацаанд үндэсний сүлжээг бий болгох нь томоохон цар хүрээтэй цаг хугацаа ба хөрөнгийн боломж хомс юм. .

Арга хэмжээ нь хүрэх түвшинтэйгээ уялдаагүй арга хэмжээнүүдийн хувьд “4.6. Газар тариалангийн техник, тоног төхөөрөмжийг бага хүүтэй, урт хугацаатай зээлээр худалдан авах нөхцөл бүрдүүлэх” зорилтын хүрээнд “Шинээр нэвтэрч буй хөдөө аж ахуйн техникийн ашиглалтын талаарх сургалт зохион байгуулах” үйл ажиллагаа, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, мал аж ахуй эрхлэх уламжлалт арга ажиллагааг боловсронгуй болгон, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг зохистой хослон хөгжүүлж, малын үржлийн ажил, үйлчилгээг сайжруулж, бүтээмжийг нэмэгдүүлэн, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээний хүрэх түвшин “6-аас доошгүй сүүний үхрийн аж ахуй эрхлэгчид, 2-оос доошгүй гахайн аж ахуй эрхлэгчид дэмжлэг үзүүлсэн байна” гэсэн нь шалгуур үзүүлэлтүүд арга хэмжээнийхээ агуулгаа бүрэн илэрхийлж чадахгүй, оновчгүй сонгогдсон байна. Төлөвлөсөн арга хэмжээний хүрэх түвшинг нэг л шалгуур үзүүлэлт үнэлэхээр төлөвлөгдсөн байгаа нь салбарт болон нийгэмд гарч буй үр нөлөөнд бодитой үнэлгээ хийх боломж багатай байна.

Санхүүжилт дутагдалтай арга хэмжээнүүдийн тухайд “2.8.Тоног, төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх замаар үндэсний үйлдвэрлэлийг дэмжих” арга хэмжээний хувьд Санхүүгийн түрээсийн үйлчилгээнд зориулж 2016 оны төсөвт хөрөнгийн эх үүсвэр хуваарилагдаагүйгээс энэ заалт бүрэн хэрэгжээгүй байна.

Мөн “Хоногт 2-5 тонн сүү хөргөх хүчин чадалтай хөргөлтийн төвүүдийг байгуулах” арга хэмжээний хувьд Хятадын “ЭКЗИМ” банкны удирдлагуудтай хийсэн Сангийн яам, ХХААЯ-ны уулзалтаар “ санал болгож буй сүүний хөргөлтийн 50 төвийг хөнгөлөлттэй нөхцөлөөр манай аж ахуйн нэгжүүд авах боломжгүй” гэсэн тул Засгийн газрын 2015 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн “Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслүүдийн тухай” 309 дүгээр тогтоолоор дээрх зээлийн хөрөнгийн зориулалтыг өөрчилсөн тул бүрэн хэрэгжих боломжгүй болжээ.

Эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд Малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх чиглэлээр гурван арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд улсын төсвөөс 11.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг энэ арга хэмжээнд зарцуулахаар баталсан байна. Малын халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын 85.9 хувь нь Бруцеллёз өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын 92.2 хувийг тус тус зарцуулсан байна.

Шүлхий болон хонины цэцэг өвчний тархалт нэмэгдсэн, бог малын мялзан өвчин шинээр гарсантай холбоотойгоор гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал 5.4 дахин өсөж мал эмнэлгийн арга хэмжээнд нийт 24.6 тэрбум төгрөг зарцуулсан байна. Үндсэн чиглэлийн хүрээнд 2016 онд малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хангалттай хэрэгжиж зохих үр дүнд хүрсэн болох нь тандалт судалгаа, шинжилгээний ажлын үр дүнгээр нотлогдсон байна.

Дөрөв. Дүгнэлт, зөвлөмж

1. Монгол улсын Эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуйн салбарт хамаарах арга хэмжээний ерөнхий гүйцэтгэл 2016 оны жилийн эцсийн байдлаар **80.3** хувьтай үнэлэгдсэн ба тасарсан арга хэмжээ байхгүй байна.
2. Үндсэн чиглэлийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг тайлагнах ажилд төлөвлөлтийн болон хэрэгжилтийг хангах газар, хэлтсүүд нягт хамтран ажиллаж чадаагүй дутагдалтай харагдаж байна. Тухайлбал зарим арга хэмжээнд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй, оновчтой бус төлөвлөсөнөөс ажлын хөрөнгийн зориулалт өөрчлөгдсөн зэргээс шалтгаалан бүрэн хэрэгжиж дуусаагүй арга хэмжээнүүд байгаад анхаарал хандуулах хэрэгтэй байна.
3. Шүлхий болон хонины цэцэг өвчний тархалт нэмэгдсэн, бог малын мялзан өвчин шинээр гарч гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал нэмэгдэж байгаад анхаарал хандуулж, төлөвлөсөн хөрөнгийн тодорхой хувийг тандалт судалгаа, шинжилгээний ажилд зарцуулж, хамрах хүрээг өргөжүүлэх нь төсвийн хөрөнгийг үр дүнтэй ашиглах ач холбогдолтой юм.
4. 2016 оны үндсэн чиглэлд хүнс, хөдөө аж ахуйн салбарт 34.485 (улсын төсвөөс 10.685,2, хувийн хэвшлээс 2.5, гадаад эх үүсвэрээс 21.3), аж үйлдвэрийн салбарт 245.6 (улсын төсвөөс 0.6, Засгийн газрын үнэт цаас борлуулсан хөрөнгөнөөс 110.0, төр-хувийн хэвшлийн түншлэлээр 135.0) нийт 280.1 тэрбум төгрөг тус тус төлөвлөсөнөөс 232.4 тэрбум төгрөг, 58.8 сая ам.доллар (хүнс, хөдөө аж ахуйн салбарт 56.3, аж үйлдвэрийн салбарт 176.1 тэрбум төгрөг) зарцуулсан.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
 ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
 ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
 Т О В Ч О О Н
 (2016 оны жилийн эцсийн байдлаар)

Бодлого	Зорилт	Арга хэмжээ	Арга хэмжээний биелэлт, хувиар							Дундаж, %
			100	90	70	50	30	10	0	
- Макро эдийн засгийн бодлого; -Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого; - Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого;	6	35	16	8	3	5	-	3	-	80.3

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
 ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
 ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
 Т О В Ч О О Н
 (салбар бүрээр)

		2016 он	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАР						
			БТГ	МААБХЗГ	ГТБХЗГ	ХөҮБХЗГ	ЖДҮХБХЗГ	ХҮҮБХЗГ	
Нийт		35	2	18	7	5	3	1	
Үүнээс	Биелсэн	16	-	8	4	4	-	-	
	Үүнээс	Бүгд	19	2	10	3	1	1	1
		90%	8	-	5	2	-	1	-
		70%	3	-	3	-	-	-	-
		50%	5	1	1	-	1	1	1
		30%	-	-	-	-	-	-	-
		10%	3	1	-	1	-	1	-
	Тасарсан	-	-	-	-	-	-	-	
Үнэлгээ		80.3	30.0	88.8	84.3	90.0	50.0	50.0	

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ**

/2016 оны жилийн эцсийн байдлаар/

№	Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Зорилт, арга хэмжээ	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн	Төсөв зарцуулалт	Хүрсэн түвшин, биелэлт	Үсгэн Ү
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО								
Зорилт 2. Санхүүгийн эх үүсвэрүүдийг бүрэн дайчилж, үр ашгийг дээшлүүлэх замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.								
1	Экспортыг дэмжих хөтөлбөрийн 3.1 дэх заалт	Санхүүгийн эх үүсвэрүүдийг бүрэн дайчилж, үр ашгийг дээшлүүлэх замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ	2.8.Тоног, төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх замаар үндэсний үйлдвэрлэлийг дэмжих;	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	0.0	-Сангийн яамнаас ЕХ-ны EBRD /Европын сэргээн босголт хөгжлийн банк/ төсөлд захиалга өгч санхүүгийн түрээсийн олон улсын зөвлөх авч “Санхүүгийн түрээсийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгыг хийлгэж төслийг Засгийн газарт хүргүүлсэн. -Санхүүгийн түрээсийн үйлчилгээнд зориулж 2016 оны төсөвт хөрөнгийн эх үүсвэр хуваарилаагүйгээс энэ заалт бүрэн хэрэгжээгүй.	10.0
Зорилт 3. Гадаад худалдааны таатай орчныг бүрдүүлж, экспортыг дэмжих бодлого хэрэгжүүлнэ								
2	ЭЗХГАХХ-ийн 10.5 дахь заалт	Гадаад худалдааны таатай орчныг бүрдүүлж, экспортыг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.	3.1. Тарифын болон тарифын бус саад тотгорыг бууруулж, хөрш болон гуравдагч орны зах зээлд хөнгөлөлттэй нөхцлөөр бараа, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг бүрдүүлэх;	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	0.0	-Эдийн засгийн түншлэлийн тухай Монгол Улс, Япон Улс хоорондын хэлэлцээрийг 2015 оны 02 дугаар сарын 15-ны өдөр УИХ-аар соёрхон батлуулсан. Энэ ажлын хүрээнд оёмол, сүлжмэл бүтээгдэхүүнийг Япон улсын зах зээлд татваргүй гарах боломж бүрдсэн. -Хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд УИХ-ын 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Гаалийн тухай хууль, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, УИХ-ын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Онцгой албан татварын тухай хууль, “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” УИХ-ын 27 дугаар тогтоолд тус тус нэмэлт өөрчлөлт оруулан батлуулснаар Монголын тал тус хэлэлцээрийг хэрэгжүүлж эхлэхэд шаардлагатай хууль эрх зүйн өөрчлөлтийг хийж дуусгасан. -2016 оны 05 дугаар сарын 08-ны өдөр Улаанбаатар хотноо хоёр улсын Гадаад хэргийн яам хооронд ноот бичиг солилцож	100.0

						<p>хэлэлцээрийг 06 дугаар сарын 07-ны өдрөөс хэрэгжүүлж эхлэхээр талууд тохиролцсон. Тус хэлэлцээр хэрэгжиж эхэлснээр манай улсаас Япон Улс руу экспортолж буй зарим бараа бүтээгдэхүүнд хөнгөлөлттэй тариф хэрэглэх боломжтой болсон.</p> <p>-Засгийн газрын 2016 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн хуралдаанаар “Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг шинэчлэн батлуулсан. Хөтөлбөрийн хүрээнд Сангийн яамны шийдвэрээр “Экспортыг дэмжих хөрөнгө оруулалтын сан”-г Хөгжлийн банкинд байгуулах хэрэгжилтийг хангах чиглэлээр холбогдох саналыг өгч хамтран ажиллаж байна.</p> <p>-Монгол Улсын гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 60 гаруй буюу экспортын 90 гаруй, импортын 30 хувийг эзэлдэг Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрт нэгдэн орохоор ажиллаж байна.</p> <p>-Үүний хүрээнд хэлэлцээрт нэгдэн орох тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан 2015 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж дэмжүүлсэн.</p> <p>-Монгол, Орос хоёр улсын худалдааны харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор “Монгол Улсын Засгийн газар, Евразийн эдийн засгийн комисс хоорондын хамтран ажиллах тухай санамж бичиг”-ийн төслийг боловсруулсан. Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг, Евразийн эдийн засгийн комиссын дарга Б.В.Христенко нар 2015 оны 06 дугаар сарын 17-ны өдөр Москва хотноо уг Санамж бичигт гарын үсэг зурсан. Тус санамж бичигт хоёр талын худалдаанд тулгарч буй тарифын болон тарифын бус саад тотгорыг арилгах чиглэлээр хамтран ажиллахаар туссан.</p> <p>-Монгол Улсын Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж 2015 оны 11 дүгээр сарын 9-өөс 11-ний өдрүүдэд БНХАУ-д хийсэн төрийн айлчлалын үер Монгол Улсын Аж үйлдвэрийн яам, БНХАУ-ын Худалдааны яам хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх тухай харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Тус санамж бичигт хоёр тал хамтран цөөн нэрийн бараа бүтээгдэхүүнээр чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг судлахаар тусгасан.</p> <p>-Япон улсын зах зээлд 5 жилийн хугацаанд 15.0 сая ам долларын оёмол хувцасыг Монголд үйлдвэрлэн борлуулах гэрээг Японы улсын “Суперрийжинг” компанитай байгуулсан ба 2017 оноос бүтээгдэхүүн гаргах бэлтгэл ажлыг хангаж байна. Ноос, ноолууран нэхмэл бүтээгдэхүүний экспорт 2015 онд 222.7 тэрбум байсан бол 2016 оны байдлаар 283.0 тэрбумд хүрч, Япон улсад хийгдсэн экспортын эзлэх хувийн жин 2.6 хувиар өссөн байна.</p>
--	--	--	--	--	--	---

3	ЗГҮАХХАХТ-ний 61.1, 61.2 дахь заалт	Гадаад худалдааны таатай орчныг бүрдүүлж, экспортыг дэмжих бодлого хэрэгжүүлнэ	3.2. Дэлхийн худалдааны байгууллагатай тохирсон хэмжээнд багтаан импортын зарим бараанд ногдуулах гаалийн татварыг нэмэгдүүлж, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих;	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	0.0	-Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Дэлхийн худалдааны байгууллагад элсэхдээ хүлээсэн үүргийн хүрээнд УИХ-ын 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 74 дүгээр тогтоолыг батлуулсан. -Тус тогтоолоор нийт 32 бүлгийн гаалийн албан татварын хувь, хэмжээг тухайн салбарын онцлогийг харгалзан тогтоох эрхийг Засгийн газарт олгосон. Засгийн газрын 2015 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн 332 дугаар тогтоолоор 5 бүлгийн, 12 төрлийн барааны импортын гаалийн тарифыг нэмэгдүүлсэн. Үүнд: мах, дайвар мах (адуу, үхэр, хонь, ямаа, тэмээ), зөгийн бал, нөөшилсөн бүтээгдэхүүн, цемент, троллейбус гэх мэт. -Засгийн газрын 2016 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 185 дугаар тогтоолоор 14 бүлгийн 28 зүйлийн 100 гаруй нэр, төрлийн бараа, бүтээгдэхүүний импортын гаалийн албан татварыг тус тус нэмэгдүүлсэн.	100.0
---	-------------------------------------	--	---	-----------------------------------	-------	-----	--	-------

Зорилт 4. Мал аж ахуй, газар тариалангийн салбарын хөгжлийг эрчимжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

4	"Монгол мал" үндэсний хөгөлбөрийн 3.2.1, 3.2.3 дахь заалт	4.1. Үржлийн цөм сүргийн малын тоог нэмэгдүүлэх	4.1.1 Баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг, ангилалт явуулж стандартын шаардлага хангасан хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлэх, дутагдаж буй хээлтүүлэгчийг шинээр нөхөн тавих;	Үржлийн үзлэг ангилалтад хамрагдах өсвөр малын тооны өсөлт, хувиар	20.0-иос доошгүй	0.2 Улсын төсөв	- ХХАА-н сайдын 216 оны 02 дугаар сарын А-26 тоот тушаалаар үржлийн ажлын үзлэг, ангилалтын ажлыг зохион байгуулахад 170.0 сая төгрөгийг баталж МЭҮГ-т нийт зардлын дүнгийн 80 хувийг шилжүүлсэн. ХХАА-н сайдын тушаалын дагуу МЭҮГ-ын даргын А/17 тоот тушаал, удирдамж гарч 10 аймгийн ХХААГ-тай “Малд үзлэг, ангилалт хийж цөм сүрэг бүрдүүлэх тухай” гэрээг байгуулан 191.1 мянган малд үзлэг, ангилалт хийх ажлыг орон нутагт зохион байгуулав. - Гэрээний дагуу 10 аймгийн ХХААГ орон нутгийн 17 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан 203.0 мянган малд үзлэг ангилалт хийж анги чанарыг тогтоов. Ангилалтын дүнгээр нийт малын 13.6 хувь буюу 27.6 мянган толгой мал шилмэл ангид, 32.6 хувь буюу 66.2 мянган толгой мал үржлийн нэгдүгээр ангийн шаардлагыг хангасан дүнтэй байна. Үзлэг ангилалтын тайланг үндэслэн үлдэгдэл 20 хувийн санхүүжилтыг гүйцэтгэлээр аймгуудад олгов. -Улсын хэмжээнд 82 нэгж малын үржлийн ажил үйлчилгээний чиглэлээр ажиллаж байгаа бөгөөд эдгээрийн 38 нь улсын хэмжээний нийт бог малын хээлтүүлэгчийн 18.9 хувь буюу 56.1 мянган толгой хуц, ухныг хээлтүүлгийн бус үед эх сүргээс тусгаарлан маллах ажиллагааг аймаг, сумдын мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулав. -Улсын хэмжээнд нийт 27.3 мянган хээлтүүлэгч шинээр нөхөн тавьсан бөгөөд үүний 12.2 мянга нь хуц, 10.0 мянга нь ухна байна. /176 сая/	90.0
---	---	---	---	--	------------------	-----------------	--	------

				Стандартад нийцэж баталгаажсан хээлтүүлэгчийн тооны өсөлт, хувиар	20.0-иос доошгүй		-Улсын хэмжээнд 464.1 мянган хээлтүүлэгч байгаагаас үзлэг ангилалтад 8.5 мянган малд үзлэг ангилалт хийж анги чанарыг тогтоов. Нийт ангилалтанд хамрагдсан хээлтүүлэгчийн 63.2 хувь буюу 5420.0 мянга нь шилмэл 1 дүгээр ангийн шаардлага хангасан байна. Монгол улсын хэмжээнд 279 өрх, 6 аж ахуйн нэгжид үржлийн мал бойжуулах эрх олгон 26.9 мянган толгой хээлтэгчийг үржлийн бүртгэлд авсан.	90.0
5	"Монгол мал" үндэсний хөтөлбөрийн 3.2 дахь заалт	4.2. Төв, суурин газрын ойролцоо мах, сүүний чиглэлийн хонь, үхрийн болон гахай, шувууны фермерийн аж ахуй байгуулж, дотоодын хэрэгцээг хангах, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;	4.2.1 Сүүний үхрийн аж ахуй эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх;	Дэмжлэг үзүүлсэн аж ахуйн тоо	6-аас доошгүй	0.3 Мал хамгаалах сан	-Төв, суурин газрын ойролцоо үйл ажиллагаа явуулж буй сүүний чиглэлийн үхрийн аж ахуйн эрхлэгчдэд нийт 300.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэхээр төсөл сонгон шалгаруулалтыг зохион байгуулж 26 аж ахуйн нэгжид 5-н жилийн хугацаатай 300.0 сая төгрөгний зээл олгох ажлыг зохион байгуулсан.	100
			4.2.2 Гахайн аж ахуй эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх;	Дэмжлэг үзүүлсэн аж ахуйн тоо	2-оос доошгүй	0.1 Мал хамгаалах сан	-Гахайн цогцолбор аж ахуйд дэмжлэг үзүүлэх төсөл сонгон шалгаруулалтын баримт бичгийг боловсруулан зарлан холбогдох материалуудыг хүлээн авч ажлын хэсгийн гишүүдээр хэлэлцүүлэн шаардлага хангасан "Ургац хангай" ХХК-ийн ирүүлсэн төслийг шалгаруулан 109.0 сая төгрөгийн гэрээ байгуулж, олгов. Төслийн үр дүнд гахайн махны үйлдвэрлэл 200 тн-оор нэмэгдэнэ гэж үзсэн.	70.0
6	"Монгол мал" үндэсний хөтөлбөрийн 3.2 дахь заалт	4.3. Монгол малын генийн санг хамгаалах, малын нөхөн үржилд биотехнологийн ололтыг нэвтрүүлэх ажлын цар хүрээг нэмэгдүүлэх;	4.3.1 Малын удмын сангийн үндэсний цогцолбор барих; /Дархан-Уул, Хонгор сум/	Малын удмын сангийн үндэсний цогцолбор барих ажлын явц, хувиар	100	1.3	-“Монгол мал” хөтөлбөрийн хүрээнд Дархан-Уул аймгийн Хонгор суманд шинээр байгуулж буй Малын удмын сангийн үндэсний цогцолборын /Дархан-Уул, Хонгор-XXVIII.1.5/ инженерийн иж бүрэн шугам сүлжээ болон барилга угсралтын ажлын эхний ээлжийн ажлыг гүйцэтгэгч “НАБСАН” ХХК-тай хийсэн гэрээт ажлын гүйцэтгэл 2016 оны эцсийн байдлаар 98.0 хувьтай байна. -Цогцолборын захиргаа, үйлдвэрлэл, малын байрны зориулалттай 14 барилгын угсралтын ажил, 11.0 км урт газар доорх инженерийн шугам сүлжээний ажил бүрэн дууссан, энэ ажилд улсын төсвөөс 12.2 тэрбум төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна. -Цогцолборын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай байгаа цэвэр усан хангамж, цахилгааны дэд өртөө, агаарын шугам, гадна холбооны шугам, цэвэрлэх байгууламжийн ажлын хөрөнгийг шийдвэрлэснээр 2017 оны эхний хагас жилд багтаан дуусгаж, улсын комисст хүлээн авахаар гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан ажиллаж байна.	90


10 7	"Монгол мал" үндэсний хөтөлбөрийн 3.4 дэх заалт	4.4. Улсын тусгай хэрэгцээнд авах отрын бэлчээрийн талбайн ашиглалтыг сайжруулах, аймаг дундын болон сум дундын отрын бүсийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх	4.4.1. Отрын бэлчээр нутгийн хил заагийг тэмдэгжүүлэх, тусгай хэрэгцээний дундын отрын бэлчээрийн судалгаа, мэдээлэл бэлтгэх;	Тусгай хэрэгцээнд шинээр авах бэлчээрийн талбайн хэмжээ, мянган га	50 –иас доошгүй	0.05 Улсын төсөв	-Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын Ховд аймгийн Баяннурууны бүс нутгийн 102.5 мянган га бэлчээрийг тэмдэгжүүлэх ажлыг ХХААЯамтай "Аддес Граф Икс" ХХК-тай АГГ160420/05-044 тоот гэрээг байгуулж нийт 38,063,318.0 төгрөгийн төсөвт өртгөөр 20 ширхэг самбарыг суурилуулж, тэмдэгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.	100.0
			4.4.2.Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх; ажлын явц, хувиар	-	100.0	-	-Аймаг дундын отрын бүс нутгийн нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх зорилгоор нийт 9-н отрын бүс нутгийн бэлчээрийн даац, отроор өвөлжиж байгаа малчин өрх, малын судалгаа, отрын бүс нутагт байгаа өвсний саравч, тэжээлийн агуулах, чулуун хороо, худаг уст цэгийн байршил, түүний ашиглалтын байдлын талаарх мэдээллийг нэгтгэн бэлтгэж ТНБД-ын 2016 оны А-142 дугаар тушаалаар байгуулагдсан салбарын мэдээллийн сан бүрдүүлэх ажлын хэсэгт хүлээлгэн өгөв.	100.0/ 50,0
			4.4.3 Аймаг дундын отрын бэлчээрийг өргөтгөх судалгаа хийх, дүгнэлт гаргах;	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	0.02 Улсын төсөв	-ХХАА-н сайдын 2016 оны А-56 дугаар тушаалын дагуу Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох, Төмөрбулаг сумын нийт 35,000 га талбайд 9.0 сая төгрөгөөр бэлчээрийн судалгааны ажлыг хийлгэх ажлыг зохион байгуулж байна. Судалгаанд үндэслэн дээрх газрыг аймаг дундын отрын бэлчээр болгох асуудлыг аймаг, сум, багийн Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн холбогдох шийдвэрийг гаргуулах бэлтгэл ажлыг хангаж байна.	70.0
8	"Монгол мал" үндэсний хөтөлбөрийн 3.3.1 дэх заалт, ЗГҮАХХАХТ-ний 78.9, 168.3 дахь заалт	4.5. Малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх;	4.5.1 Малын халдварт өвчинтэй тэмцэх урьдчилан сэргийлэх арга хэмжээ;	Эрүүлжүүлэх арга хэмжээнд хамрагдах малын тоо	Давхард сан тоогоор 36.4 сая мал	3.7 Улсын төсөв	-Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх чиглэлээр 2016 онд 19 нэрийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд давхардсан тоогоор 37.5 сая толгой мал хамруулахаар төлөвлөснөөс 36.8 сая толгой мал хамруулж төлөвлөгөө 98.1 хувиар биелэгдсэн. Үүний дотор бруцеллёзын вакцинжуулалтад 13,4 сая толгой мал хамрагдсан. Лабораторийн 22 нэр төрлийн шинжилгээнд 556,0 мянган мал хамруулахаар төлөвлөн зорилтоо бүрэн биелүүллээ. Энэ арга хэмжээг хэрэгжүүлэхээр Биокорбинат ТӨААТҮГ-тай нийт 5,331 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн худалдан авах гэрээ байгуулан ажилласан байна.	100.0
			4.5.2 Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ;	Эрүүлжүүлэх арга хэмжээнд хамрагдах малын тоо	Давхард сан тоогоор 8.0 сая мал	3.1 Улсын төсөв	-Энэ жил төлөвлөгөөт болон зайлшгүй шаардлагаар яаралтай дархлаажуулалтанд зориулан ОХУ-д үйлдвэрлэсэн 3.0 сая тун вакциныг 3.042 тэрбум, Энэтхэг улсад үйлдвэрлэсэн 7.2 сая тун вакциныг 5.8 тэрбум төгрөг, нийт 10.2 сая тун вакциныг 8.8 тэрбум төгрөгөөр худалдан авч нийлүүлсэн. 2016 оны жилийн эцсээр байдлаар давхардсан тоогоор 10 аймгийн 161 сумын 42432 өрхийн 4.7 мянган толгой тэмээ, 184.7 мянган толгой үхэр, 4566.0 мянган	90.0

						<p>хонь, 3561.5 мянган толгой ямаа, 314 гахай нийт 9.9 толгой сая малыг хамруулж, үйлчилгээний хөлсөнд нийт 1.6 тэрбум төгрөг олгосон. УМЭАЦГЛ тандалт шинжилгээ хийхэд баруун бүсийн БӨ, ХО аймгаас бусад аймгууд, төвийн бүсийн сонгосон 5 аймагт шүлхий өвчний байгалийн халдвар илрээгүй бөгөөд зүүн бүсийн Сүхбаатар, Дорноговь аймгуудад эерэг дүн илэрсэн байна.</p> <p>- Хонины цэцэг өвчний вакцинжуулалтанд 2016 онд нийт 11 аймаг, нийслэлийн 145 сум, дүүргийн 16879 малчин өрхийн 6.6 сая толгой хонь хамруулж үйлчилгээний хөлсөнд 997.8 сая төгрөг олгосон. Үүнээс 4.1 сая толгой мал дархлаажуулах үйлчилгээний хөлс 617.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 2.5 сая толгой мал дархлаажуулах үйлчилгээний хөлс 380.5 сая төгрөгийг НҮБ-ийн байгууллагын яаралтай тусламжын төслөөс тус тус санхүүжүүлсэн. үйлчилгээний хөлсний зардалд олгоод байна. Энэ хүрээнд Биокомбинат ТӨААТҮГ-тай гэрээ байгуулж 6.2 сая тун вакцин худалдан авсан. Мөн ЗГ-ын тогтоолын дагуу ОХУ-ын Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах холбооноос нэн хөнгөлөлтэй нөхцлөөр 23.6 сая тун вакцин худалдан авах гэрээ байгуулсан бөгөөд эхний 5.0 сая тун вакциныг 2016.12.26-ны өдөр хүлээн аваад байна. Хонины цэцгийн вакцин таригдсан аймаг, сумдын малчин өрхөөс санамсаргүй түүврийн аргаар сорьц авч шинжилгээ хийхэд Нийслэл, Говьсүмбэр, Төв, Сүхбаатар, Хэнтий, Дорнод, Дундговь, Дорноговь аймгийн шинжлэгдсэн нийт малын 83.5-98 хувийн дархлаатай байгаа нь тогтоогдсон.</p> <p>- Бог малын мялзан өвчнөөс сэргийлэх яаралтай дархлаажуулалтад 5 аймгийн 70 сумын 23959 малчин өрхийн 4.6 сая толгой хонь, 5.8 сая толгой ямаа, нийт 10.4 сая толгой бог малыг вакцинжуулалтанд хамруулж үйлчилгээний хөлсөнд 1.5 тэрбум төгрөгийг бүрэн олгосон. Бог малын мялзангаас сэргийлэх вакцин худалдан авах ажиллагааг Засгийн газрын 2016 оны 71 дүгээр тогтоолын хүрээнд зохион байгуулж БНХАУ-д үйлдвэрлэсэн 11.5 сая тун вакцин худалдан авахад 3.9 тэрбум төгрөгийг зарцуулсан. Бог малын мялзан өвчний тохиолдол бүртгэгдсэн болон түүнтэй хил залгаа Ховд, Увс, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан аймгийн 20 сумыг хамруулан тандан шинжилгээ хийхэд вирусын эсрэг төрөгч илэрсэн.</p>	
		4.5.3 Бруцеллэз өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ;	Бруцеллэз өвчний гаралтыг бууруулах хувь	10	2.5 Улсын төсөв	-Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2016 онд 16.6 сая мал хамруулахаар төлөвлөж, вакцины зардалд 2.5 тэрбум төгрөг, үйлчилгээний хөлсөнд 2.6 тэрбум төгрөг бүгд 5.1 тэрбум төгрөг батлагдаж, Биокомбинат ТӨААТҮГ-тай бүтээгдэхүүн нийлүүлэх МЭТШ//БИО/2016-1 дугаар гэрээ байгуулан ажилласан.	100.0


						<p>-2016 онд мал эмнэлгийн арга хэмжээний төсөв санхүүгийн хүндрэлээс шалтгаалан 3.0 сая тун буюу 450.0 сая төгрөгний вакциныг захиалгаас хасах саналыг Биокомбинат ТӨААТҮГ-т хүргүүлж гэрээнд өөрчлөлт оруулсан. Гэрээний дагуу 13.5 сая тун вакциныг нийлүүлж улсын хэмжээнд 21 аймгийн 316 сумын охин тугал 641.3 мянга, богийн төл 12.7 сая, нийт 13.3 сая толгой мал хамрагдаж төлөвлөгөө 97.7 хувиар биелэсэн. Энэхүү арга хэмжээнд зориулан улсын төсвөөс 2 нэрийн вакцин, шингэлэгчийн үнэнд 2.15 тэрбум, үйлчилгээний хөлсөнд 2.03 тэрбум нийт 4.18 тэрбум төгрөг зарцуулсан. -Бруцеллёзын вакцинжуулалтын дараах тандалт хийх ажлыг Швейцарын хөгжлийн агентлагийн Малын эрүүл мэнд төсөлтэй хамтран хэрэгжүүлж, Хөвсгөл, Булган, Сэлэнгэ, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар зэрэг 6 аймгийн нийт 12 суманд 120 гаруй өрхийн 6000 малаас санамсаргүй аргаар дээжийг сонгон авч шинжилгээнд хамруулав. Шинжилгээнд шаардагдах 9 төрлийн 6,235,048.0 төгрөгийн багаж хэрэгслийг МЭҮГ-ын нөөцөөс УМЭАЦТЛ-т хуваарилан олгож, Швейцарын хөгжлийн агентлагийн -ын Малын эрүүл мэнд төслөөс 6 аймагт серомониторинг хийгдэх томилолт, шатахууны зардалд нийтдээ 17.34 сая төгрөгийг зарцуулан УМЭАЦТЛ-ийн удирдамж, чиглэл, зааварын дагуу гүйцэтгэсэн байна. -Бруцеллёзтой тэмцэх стратеги, төлөвлөгөөний дагуу 2016 онд бруцеллёзын чиглэлээр зорилтот шинжилгээ хийгдэх МЭХ-нд цаабуганд тандалт хийхэд 2,520.8 мян.төг, Нийслэлийн мал эмнэлгийн эрчимжсэн аж ахуйн үхэр сүргийн шинжилгээнд 928.0 мян.төг, Өмнөговь аймагт хэрэгжүүлэх тэмээний бруцеллёзын шинжилгээний тандалтад 1,688.5 мян төгрөгийн багаж хэрэгсэл /цусны хуруу шил, цодон, зүү, зүү баригч, 3 төрлийн соруурын хошуу, ийлдэс хадгалах хайрцаг/-ийг тус тус олгох хуваарийг гаргаж, МЭҮГ-ын газрын даргаар баглуулан, Мал эмнэлэг, үржлийн газрын нөөцөөс олгож хэрэгжилтийг хангаж ажиллав. -Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй “Малын эрүүл мэнд” төсөлтэй хамтран бруцеллёзын вакцинжуулалтын дараах хяналтын шинжилгээ (серомониторинг) хийх, сургалтыг санамсаргүй түүврийн аргаар сонгож тандалтанд хамрагдсан 6 аймагт зохион байгуулж, гарын авлага зааварчлагаар хангаж ажилласан байна. Санамсаргүй түүврийн аргаар сонгож авсан дээжинд хийгдсэн шинжилгээний дүнгээр улсын хэмжээнд бог малд 65 хувьд, бод малын 60 хувьд дархлаа тогтсон болох нь тогтоогджээ. Вакцины зардалд 2.5 тэрбум, үйлчилгээний хөлс 2.6 турбум төгрөг зарцуулсан байна.</p>
--	--	--	--	--	--	--

9	ЗГҮАХХАХТ-ний 93 дахь заалт	4.6. Газар тариалангийн техник, тоног төхөөрөмжийг бага хүүтэй, урт хугацаатай зээлээр худалдан авах нөхцөлийг бүрдүүлэх;	4.6.1 Шинээр нэвтэрч буй хөдөө аж ахуйн техникийн ашиглалтын талаархи сургалт зохион байгуулах;	Техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын явц, хувиар	75.0	10.0 Гадаад эх үүсвэр	-2016 онд ТЭДС-гаас БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд нийлүүлэгдсэн нийт 2.4 тэрбум төгрөгийн үнэ бүхий 125-165 морины хүчтэй 20 ширхэг тракторыг тариаланчдад 20 хувийн урьдчилгаа төлбөртэй 5 жилийн хугацаатай зээлээр мөн тус зээлийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн нийт 5.2 тэрбум төгрөгийн үнэ бүхий 1035 ширхэг бага оврын тракторыг хөнгөлөлттэй зээлээр олгосон. -Засгийн газрын 2016 оны 04 дүгээр сарын 04-ны өдрийн 197 дугаар тогтоолоор Гааль болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх ХАА-н зориулалттай техникийн жагсаалтыг баталсан. Газар тариалангийн техникийн шинэчлэл 67.0 хувьтай байна.	90.0
				Сургалтанд хамрагдсан ажилчдын тоо	90-с доошгүй	0.015 Улсын төсөв	-Тариаланчдын улсын зөвлөгөөний үеэр газар тариаланд шинээр нэвтэрч буй техникийн бүтээлийн болон шатахуун зарцуулалтын үлгэрчилсэн нормыг ашиглах сургалт зохион байгуулж 50 инженер, техникийн ажилчид хамрагдав. -Дэвшилтэт технологид суурилсан хөдөө аж ахуйн техникийн ашиглалт, засвар үйлчилгээний сургалтыг зохион байгуулж сургалтад газар тариалангийн үйлдвэрлэлд ажиллаж буй 40 инженер, техникийн ажилтныг оролцуулав. -“Газар тариалангийн үйлдвэрлэлийн засвар үйлчилгээний системийг боловсронгуй болгох” семинарыг ХААИС-тай хамтран зохион байгуулав. Энэхүү сургалт семинарт 20 инженер техникийн ажилтан, судлаачид оролцов.	100.0
		4.6.3 Улаанбуудайн элит үр үржүүлэх, нөөц бүрдүүлэх;	Элит үр үйлдвэрлэлийн хэмжээ, тн	200-аас доошгүй	0.18 Улсын төсөв	0,446	-2016 онд Үр тариа, тэжээлийн таримлын шинэ сорт гаргах, нутагшсан сортын үр үржүүлэх, нөөц бүрдүүлэх зорилгоор “Улаан буудайн элит үр үржүүлж нийлүүлэх”, “Таримлын сэлгээний оновчтой бүтэц тогтоох, шинэ таримлын элит үр үржүүлж нийлүүлэх” худалдан авах ажиллагааг зарлан дүгнэж, шалгарсан Дархан-Уул аймаг дахь Ургамал газар тариалангийн хүрээлэнтэй нийт 344 тонн буудайн элит үрийг 291.0 сая төгрөгт, 180 тонн тэжээлийн таримлын элит үрийг 155.0 сая төгрөгт тус тус багтаан нийлүүлэх гэрээ байгуулж дүгнэснээр ТЭДС-гийн агуулахад уг элит үрийг хүлээн авч нөөц бүрдүүлэв. -Мөн Монгол орны цаг уурын нөхцөлд тохирсон эрт болцтой ган, өвчинд тэсвэртэй үр тариа, тэжээлийн таримлын шинэ сорт гаргах, нутагшсан сортын үр үржүүлэх зорилгоор төсөл боловсруулан ОХУ-ын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлэхээр төслийг хүргүүлэв. -Энэ хаврын тариалалтад зориулан ОХУ-аас 6.5 мянган тонн үрийн буудайг импортоор авч нөөц бүрдүүлснээр ТЭДС-аас нийт 345 аж	100.0

							ахуйн нэгжид 12.1 мянган тонн буудайн үрийг 10-30 хувийн урьдчилгаатай зээлээр олгож тариалалтыг төлөвлөсөн хэмжээнээс 15 хувиар ахиу тариалав.	
10	ЗГҮАХХАХТ-ний 93 дахь заалт, “Чацаргана” Үндэсний хөтөлбөр, ҮХЦБ-ын 5.2.1.4.5 дахь зорилт	4.7. Чихрийн манжин тариалж, элсэн чихэр үйлдвэрлэх, чацаргана болон бусад жимсний тариалалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг бодлогоор дэмжих	4.7.1 Хөрсний үржил шимийг хамгаалах нийлмэл бордоо нийлүүлэх;	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	-2013 онд импортыг багасгаж, экспортыг дэмжих чиглэлээр Монгол Улсад чихрийн манжин тариалж элсэн чихэр үйлдвэрлэх ажлын хэсэг ҮХАА-н Сайдын тушаалаар байгуулагдан ажиллаж, туршилтын тариалалтыг 2014 онд хийсэн боловч хөрөнгө мөнгөгүйн улмаас дэмжигдээгүй болно. -Чацаргана болон жимсний тариалалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд: Жимс, жимсгэнэ тариалагчдад зориулсан сургалтыг Хөвсгөл аймагт, жимс жимсгэнэ боловсруулах технологийн сургалтыг Улаанбаатар хотод (10.0 сая төгрөгийн санхүүжилтээр) зохион байгуулж тариалагч, үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдлэг чадварыг сайжруулав. -НҮБ-ын ХХААБ-ын санхүүжилтээр “Жимс жимсгэнэ” төслийг хэрэгжүүлэх шийдвэр гаргуулан алим, чавга зэрэг жимс жимсгэний суулгацыг туршиж, нутагшуулах, үржүүлэх ажлыг 2017 оноос эхлүүлэхээр төлөвлөөд байна. Энэхүү төсөл нийт 190.0 мянган ам.долларын санхүүжилтээр хэрэгжинэ. -“Жимс жимсгэнэ” хөтөлбөрийн төслийг боловсруулж Засгийн газарт танилцуулахаар бэлтгэж байна.	90.0
				Нийлүүлсэн бордооны хэмжээ, тн	5000-аас доошгүй	8.9 Гадаад эх үүсвэр	-2016 онд Япон Улсын Засгийн газрын хүнсний буцалтгүй тусламжийн КР-1 төслийн хуримтлалын 8.9 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 7.9 мянган тонн нийлмэл бордоог нийлүүлж, тус эрдэс бордооны үнийн 70 хувийг хөнгөлөн тариалан эрхэлдэг 378 аж ахуйн нэгж, иргэнд 7.9 мянган тонныг олгов. Эрдэс бордоо хэрэглэснээр хураан авсан ургацын хэмжээ, чанарт мэдэгдэхүйц нөлөө үзүүлсэн гэсэн дүгнэлт хийжээ.	100
Зорилт 5.Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ.								
11	ЗГҮАХХАХТ-ний 30.2 дахь заалт	Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ	5.4. Оёмол, нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүн, ноос, ноолуур боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;	Нийт үйлдвэрлэлийн хэмжээний өсөлт, хувиар	20.0	30.0 Хөгжлийн банк	-“Ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2015 оны 149 дүгээр тогтоолыг баглуулсан. -Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд санхүүжилтийн асуудлыг Засгийн газрын 2015 оны “Ноолуурын салбарын эргэлтийн хөрөнгийн зээлийг санхүүжүүлэх тухай” 171 дүгээр тогтоолоор “Хөгжлийн банк”-д даатгасан. -2016 оны байдлаар Хувцас, оёмол бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 1 656.0 сая.төг хүрсэн ба өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1.9 хувиар өссөн ба үндэсний ноосны 99 үйлдвэр 21 944 тн ноосыг хүлээн авсан байна. Үүнээс хонины ноос 20913 тн,	100.0/

							тэмээний ноос 1030 тонныг тус тус бэлтгэн авсан. -Ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх тухай ЗГ-ын 2015 оны 149, 171 дүгээр тогтоолын дагуу 50.6 тэрбум төгрөгийн зээл авсан 9 үйлдвэр 2016 онд нийт 1999 тн түүхий ноолуур бэлтгэж, зээлийн үр дүнд 2016 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1,2 сая ширхэг сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 84.4 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн экспортлон үйлдвэрлэлт өмнөх оноос 12 хувь, экспорт 19 хувьтус тус өссөн байна. Хөгжлийн банкны дэмжлэгээр оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлд 0.3 сая төгрөг, ноос ноолуурын үйлдвэрлэлд 50.6 нийт 50.9 тэрбум төгрөгийн дэмжлэг ажлыг зохион байгуулсан.									
12	ЗГҮАХХАХТ68.1, 69.3 дахь заалт		5.5. Арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох;	Арьс ширийг дотоодод боловсруулах, хувь	60.0	80.0 Хөгжлийн банк	-Засгийн газрын 2014 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 198 дугаар тогтоол болон 2014 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 217 дугаар тогтоолоор “Арьс ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн төсөлд арилжааны банкаар дамжуулан зээл олгохоор нийт 140.4 хүртэл төгрөгийн эх үүсвэрийг гаргах ажлыг зохион байгуулсан. -2014 оны 08 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн дээрх хөнгөлөлттэй зээлийг дамжуулан зээлдүүлэхээр Хөгжлийн банктай гэрээ хийсэн арилжааны банкуудаар дамжуулан арьс ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд зээл олгох ажлыг зохион байгуулсан. -Нийт 220 тэрбум төгрөгийн зээл хүссэн 110 төсөл ирснээс сонгон шалгаруулалтаар 2016 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр 57 төсөлд 86.1 тэрбум төгрөгийн зээл олгоод байна. Арьс ширний салбар дахь зээл олголт:	100.0/								
							 <table border="1"> <caption>Олгогдсон зээл, тэрбум төгрөг</caption> <thead> <tr> <th>Year</th> <th>Value (TBD)</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>2014</td> <td>60.8</td> </tr> <tr> <td>2015</td> <td>18.8</td> </tr> <tr> <td>2016</td> <td>6.5</td> </tr> </tbody> </table>	Year	Value (TBD)	2014	60.8	2015	18.8	2016	6.5	
Year	Value (TBD)															
2014	60.8															
2015	18.8															
2016	6.5															
13	АХТ-ний 76	5.6. Хоногт 2-5 тонн сүү	5.6.1 Сүүний үйлдвэрүүдэд тоног	Байгуулах хөргөлтийн	50.0	2.4 Гадаад	-БНХАУ-ын Засгийн газрын экспортын зээлийн хөрөнгөөр 4.1 сая ам.долларын өртөгтэй “Сүүний хөргөлтийн төвийн техник, тоног	50.0/ 10.0								

		хөргөх хүчин чадалтай хөргөлтийн төвүүдийг байгуулах	төхөөрөмж нийлүүлэх;	төвийн тоо		эх үүсвэр	төхөөрөмж худалдан авах” хэлэлцээрийн дагуу 2014 оны 01 сарын 07-ны өдөр “Сүүний хөргөлтийн төвийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, машин механизм худалдан авах гэрээ”-г байгуулсан. -Гэрээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2015 оны 02 дугаар сард Хятадын “ЭКЗИМ” банкны удирдлагууд гэрээг үргэлжлүүлэх эсэх талаар Сангийн яам, ХХААЯ-ны удирдлагуудтай уулзалт зохион байгуулсан ба “Сүүний хөргөлтийн 50 төв”-ийг хөнгөлөлттэй нөхцөлөөр манай аж ахуйн нэгжүүд авах боломжгүй гэсэн саналыг манай талаас өгсөн. Иймд “Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслүүдийн тухай” Засгийн газрын 2015 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 309 дүгээр тогтоолоор дээрх хөрөнгийн эх үүсвэрийг Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих төсөлд зарцуулахаар зориулалтыг өөрчилсөн тул хэрэгжих боломжгүй болсон.	
14	ЗГҮА ХХҮА Т-ний 60.1 дэх заалт	Уул уурхайн бус салбарыг хөгжүүлэх, эмжих үндэсний хөтөлбөрийг боловсруулж батлуулах	5.9 Уул уурхайн бус салбарыг хөгжүүлэх, дэмжих үндэсний хөтөлбөрийг 2016 оны эхний хагас жилд багтаан боловсруулж батлуулах	Хөтөлбөр боловсруулах ажлын явц, хувиар	100.0	-	Уул уурхайн бус салбарыг хөгжүүлэх зорилт бүхий “Үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль”-ийг УИХ-ын намрын чуулганаар батлуулсан бөгөөд хуулийн хүрээнд экспортын үйлдвэрлэлд дэмжлэгийг олгож эхлэх зорилгоор Үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах болон дэмжлэгт хамрагдах шалгуур үзүүлэлтийг тогтоох тухай журмуудыг тус тус боловсруулж ЗГ-ын 2016 оны 04 дүгээр сарын 04-ний 193 дугаар тогтоолоор батлуулж мөрдөж эхэлсэн. Мөн уул уурхайн бус үйлдвэрлэл, хүнс хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх, экспортын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор “Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулж ЗГ-ын 2016 оны 211 дүгээр тогтоолоор батлуулсан. АҮЯ холбогдох байгууллагуудтай хамтран хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахаар ажиллаж байна.	50/100
Зорилт 6. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.								
18	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн 5.4.7 дахь заалт ЗГҮАХХАХТ-НИЙ 35.9 дэх заалт, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих		6.1. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв байгуулах;	Байгуулах төвийн тоо	5	0.6 Улсын төсөв 5.0 ТХХТ	-Баянхонгор аймгийн Инкубатор төвийн барилгын санхүүжилтэд зориулан 1.2 тэрбум төгрөгийг 2015 онд улсын төсөвтэй батлуулсан. 2015 онд санхүүжилтийн 555.0 сая төгрөгөөр барилгын ажлыг гүйцэтгэсэн. Одоо барилгын ажил 85 хувийн гүйцэтгэлтэй байна. 2016 онд төсөвт үлдсэн санхүүжилт тусгагдаагүй учраас ажил зогссон. -Эдийн засгийн хүндрэлтэй байдлын улмаас инкубатор төв байгуулах асуудлаар төсөвт хөрөнгө оруулалтын эх үүсвэр тусгагдаагүй тул энэ арга хэмжээ бүрэн биелээгүй.	50.0/10,0
15		Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн 5.4.7 дахь заалт ЗГҮАХХАХТ-НИЙ 35.9 дэх заалт, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих	6.2. Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг	Дэмжлэгт хамрагдах аж ахуйн	80-аас доошгүй	0.6 улсын төсөв,	-Зээлийн батлан даалтын сан нь 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар нийт 441 харилцагчдын 95.2 тэрбум төгрөгийн зээлд 39.1 тэрбум төгрөгийн батлан даалт гаргахаар шийдвэрлэсэн	90.0

		Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана	эрчимжүүлэх;	нэгжийн тоо		5.0 ТХХТ	байна. Нийт 441 зээлдэгчид батлан даалт гаргасаны 79.6 хувь буюу 290 нь Улаанбаатар хот, 20.4 хувь буюу 151 нь орон нутгийн зээлдэгч байна. -Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд “Зээлийн батлан даалтын системийг дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажлын байр бий болгох” төслийн зээлийн хэлэлцээрийг 2016.02.19-ны өдөр УИХ-ын ээлжит бус чуулганаар соёрхон батлуулсан. Азийн хөгжлийн банкнаас 2016- 2034 он хүртэл 60.0 сая ам долларын төсөл хэрэгжиж эхлэсэн. -Арилжааны банкинд урт хугацаатай эх үүсвэр байршуулан Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зориулсан бага хүүтэй, урт хугацаат зээл олгох/3-5 жил/, өөрийн эх үүсвэрт тохирсон 90 хувь хүртэл батлан даалт гаргах юм. -Төслийн үр дүнд зээлийн батлан даалтын тогтоцоо бүрдэх, эрх зүйн орчин, чадавхи сайжрах, жишиг загвар бий болон эдийн засгийг төрөлжүүлж, уул уурхайн бус эдийн засгийг дэмжин ажил эрхлэлт, байнгын тогтвортой ажлын байрыг нэмэгдүүлэх юм.	
Зорилт 12.Хөдөөгийн хөгжлийг дэмжиж, хүн амын амьдрах орчныг сайжруулна								
16	Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын 3.1.6 дахь заалт	12.2. Малчдыг нийгмийн даатгалд хамрагдах, малаа даатгуулах сонирхлын хөшүүргийг бий болгох;	12.2.1 Малчдыг нийгмийн даатгалд хамрагдах, малаа даатгуулах сонирхлын хөшүүргийг бий болгох;	Нийгмийн даатгалд хамрагдах малчдын тооны өсөлт, хувиар	10	-	-Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын хамтарсан албан даалгавар гарч сумдын хөдөө аж ахуйн мэргэжилтнүүдийн хүч оролцоотойгоор малчдын нийгмийн даатгалд хамралтыг сайжруулах талаар таниулга, сурталчилгаа, сургалт хийх ажлыг зохион байгуулсны үр дүнд 2016 оны байдлаар нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд 25.0 мянган малчид даатгуулсан. Сайн дураар даатгалд хамрагдсан малчдын тоо өмнөх оноос 2 дахин өссөн нь “Монгол улсын малчин” үнэмлэх авсан малчдын тоотой харьцуулахад нийгмийн даатгалд 10 хүрэхгүй хувь нь, эрүүл мэндийн даатгалд 40-өөд хувь нь даатгуулсан байна.	50.0
				Индексжүүлсэн даатгалд хамрагдах малын тооны өсөлт, хувиар	10	-	 <p>-МИД –д хамрагдсан малчин өрхийн тоо 2015 оноос 8421-ээр өсөж 18738 өрхийн 4.4 сая малыг даатгалд хамруулсан нь өнгөрсөн оноос 44.9 хувиар өсөв. МИД-ын хураамж, олгогдсон нөхөн төлбөрийн хэмжээ</p>	100.0

17	Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын 2.3.1 дэх заалт	12.3. Малчдыг орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлөө бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж, ХАА-н биржийн арилжаан дахь оролцоог нэмэгдүүлэх;	12.3.1 Малчдыг орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлөө бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж, ХАА-н биржийн арилжаан дахь оролцоог нэмэгдүүлэх;	ХАА-н биржийн арилжаанд оролцох малчдын тооны өсөлт, хувиар	15.0-аас доошгүй	-	<p>-Баянхонгор, Завхан, Говьсүмбэр, Өмнөговь, Хэнтий аймгуудад биржийн сүлжээ ороод байна.</p> <p>-Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг хэрэгжүүлэх, малчид, иргэдийг орон нутгаас биржийн арилжаанд оролцох боломжоор хангах зорилгоор Өмнөговь аймгийн “Хотол таван эрдэнэ хоршоо”- той хамтран биржийн арилжааг 2016 оны 02 дугаар сарын 22-ны өдөр амжилттай зохион байгуулсан.</p> <p>-Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих ”Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төсөл”-д Хөдөө аж ахуйн түүхий эдийн биржийн олон улсын түвшний арилжаа, клиринг-төлбөр тооцооны системийг нэвтрүүлж, орон нутгаас биржийн арилжаанд онлайн арилжаанд оролцох боломжийг бүрдүүлэх, Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд оролцогчдын чадамжийг нэмэгдүүлэх зэрэг бодлогын асуудлаар санал боловсруулж хүргүүлсэн.</p>	50.0
18	ЗГҮАХХАХТ-ний 93 дахь заалт	12.4. Хүлэмжийн аж ахуйн тоо, хэмжээг нэмэгдүүлж, таримлын нэр төрлийг олшруулах	12.4.1 Монголд улсад ашиглах хүлэмжний стандарт боловсруулах, хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн борлуулалтыг дэмжих арга хэмжээ;	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	0.02 Улсын төсөв	-Монгол Улсад ашиглах өвөл, зуны хүлэмжийн стандарт боловсруулж батлуулах 21.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй зөвлөх үйлчилгээний гэрээг Монголын хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн холбоо “ТББ”- тай байгуулж, Өвлийн халаалттай нийлэг хальсан хүлэмж MNS6637:2016, Зуны нийлэг хальсан хүлэмж 6636:2016 стандартыг боловсруулж батлуулав.	100.0
			12.4.2 Иргэдийн хүнсний ногооны хангамжид зориулсан хүлэмж барих, худаг гаргах; /Увс, Улаангом сум/	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	0.15 Улсын төсөв	-Хүлэмж, зорь байгуулах аймаг, орон нутгийн эзэмшлийн газрын координатыг Увс аймгаас ирүүлээгүй тул тендер шалгаруулалтыг зарлаагүй. Хувь хүний эзэмшлийн талбайд байгуулах санал ирүүлснийг хуулийн дагуу хэрэгжүүлэх боломжгүй гэж үзсэн.	100.0/3 0,0

19	ЗГҮАХХҮАГ-ний 34.2, 146.5 дахь заалт	12.6. Монгол мал хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийг хөгжүүлэх хүрээнд хоршоодыг дэмжиж бүх сумдад мал аж ахуйн гаралтай бараа, түүхий эд бэлтгэх үндэсний сүлжээ бий болгох	12.6.1 Монгол мал хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийг хөгжүүлэх хүрээнд хоршоодыг дэмжиж бүх сумдад мал аж ахуйн гаралтай бараа, түүхий эд бэлтгэх үндэсний сүлжээ бий болгох;	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100.0	-	-Хөдөө аж ахуйн хоршоодын чадавхийг сайжруулах зорилгоор “Ногоон алт” хөтөлбөр, “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төсөлтэй хамтран орон нутагт хоршоодын удирдлага, менежерүүдийн сургалт-семинар зохион байгуулсан.	50.0
20	ЗГҮАХХ УАГ-ний 72.6, 240.2 дахь заалт	12.7. Бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээр сэргээх, малын тэжээл бэлтгэх иргэдийн санаачилгыг дэмжих төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	12.7.1 Тал хээрийн бэлчээрт хөнөөл учруулж буй үлийн цагаан оготной тэмцэх арга хэмжээ	Бэлчээрийн талбай мян.га	400.0-аас доошгүй	1.2 Улсын төсөв	-“Үлийн цагаан оготной тэмцэх арга хэмжээг зохион байгуулах тухай” ХХААЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А-147 дугаар тушаалаар Үлийн цагаан оготны тархалтын 2016 оны судалгаа, орон нутгийн хүсэлтийг үндэслэн нийт 10 аймгийн 59 сум, отрын 2 бүс нутгийн 415.0 мянган га бэлчээрт тархсан үлийн цагаан оготной байгаль орчинд халгүй энгийн механик аргаар тэмцэх ажлыг аймаг, сумдын мэргэжлийн хяналтын байцаагч нарын дүгнэлтээр 80-аас дээш хувийн үр дүнтэйгээр гүйцэтгэсэн байна. -Мөн микробиологийн аргаар үлийн цагаан оготной тэмцэх ажлыг хавар, намар гэсэн хоёр үе шаттай зохион байгуулав.Үүнд: Дундговь аймгийн 2 сум, Өвөрхангай аймгийн 3 сум, нийт 2 аймгийн 5 сумын үлийн цагаан оготно тархсан 110.0 мянган га бэлчээрийн талбайд 220 тонн бактерийн бэлдмэлийг орон нутагтай хамтран цацаж, тэмцэх ажлыг дунджаар 83.0 хувийн үр дүнтэй гүйцэтгэсэн байна. -Бэлчээр хамгаалах арга хэмжээний хүрээнд 2016 онд нийт 10 аймгийн 67 сумын 525.0 мянган га талбайд үлийн цагаан оготной тэмцэх ажлыг зохион байгуулав.	100.0
			12.7.2. Өндөр уулын бэлчээрийн ургамалд хөнөөл	Бэлчээрийн талбай мян.га	100.0-аас доошгүй	0.6 Улсын төсөв	-ХХААЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А-188 дугаар “Царцаатай тэмцэх арга хэмжээг зохион байгуулах тухай” тушаалаар Царцаатай химийн аргаар тэмцэх ажлыг технологийн	50.0

			учруулж буй царцаатай тэмцэх арга хэмжээ				хугацаанд нь Баян-Өлгий аймгийн 5 сумын 20.0 мянган га бэлчээрт 87.3 хувийн үр дүнтэй, Ховд аймгийн 6 сумын 25.1 мянган га бэлчээрт 96.2 хувийн үр дүнтэй тус тус зохион байгуулсан. -Царцаатай 2016 онд тэмцэх ажлын гүйцэтгэлээр 2 аймгийн 11 сумын 45.1 мянган га талбайд дунджаар 91.7 хувийн үр дүнтэй тэмцэх ажлыг гүйцэтгэсэн байна.	
			12.7.3. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн таримал тэжээл тариалах ажлыг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг үзүүлсэн аж ахуйн тоо	5-аас доошгүй	0.35 Мал хамгаалах сан	-Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн таримал тэжээл тариалах ажлыг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл сонгон шалгаруулалтын баримт бичиг боловсруулан тендер зарлаж эрчимжсэн аж ахуй эрхэлж буй 10 аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж 150.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв. Үүний үр дүнд ирэх жил 100 гаруй га-д малын тэжээл тариалах боломжийг бүрдүүлсэн.	100.0
			12.7.4. Сайн чанарын тэжээлийн үр бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх	Дэмжлэг үзүүлсэн аж ахуйн тоо	5-аас доошгүй	0.15 Мал хамгаалах сан	-Сайн чанарын тэжээлийн үр бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх төсөл сонгон шалгаруулалтын баримт бичгийг боловсруулан тендер зохион байгуулж, шаардлага хангасан 1 төслийг шалгаруулан 150.0 сая төгрөгийн зээлийн дэмжлэг үзүүлэв. Төслийн үр дүнд ирэх оноос тэжээлийн арвай, хошуу буудай, хөх тариа, царгасны үр нийт 192.2 тн-ыг бэлтгэж нийлүүлэх боломж бүрдсэн гэж үзсэн.	90

---oOo---